



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/081/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Батсүх Утас: 70453799, Цахим хаяг: Batsukht@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

### **1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

### **2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
  - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
  - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
  - 3.5.3 Нэмэлт төсөв
  - 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн
  - 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
  - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
  - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
  - 4.5.1 Завсрын аудитын талаар
  - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

### **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

#### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.25 № УВА-2026/081/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050554

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>213,834,922.85</b>	<b>234,709,034.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,385,687.85</b>	<b>949,000.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,385,687.85	949,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>211,449,235.00</b>	<b>233,760,034.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>-</b>	<b>58,010,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	-	58,010,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>193,704,691.50</b>	<b>158,005,490.50</b>
35420	Аж ахуйн материал	183,094,691.50	147,395,490.50
35470	Бусад хангамжийн материал	10,610,000.00	10,610,000.00
35600	Мал амьтад	17,744,543.50	17,744,543.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,719,042,916.68</b>	<b>5,625,179,703.62</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,719,042,916.68</b>	<b>5,625,179,703.62</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,315,810,516.68</b>	<b>5,221,783,303.62</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,471,436,535.55	5,545,785,438.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	(725,016,338.49)	(859,234,190.22)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	386,686,246.00	371,416,846.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(144,966,653.16)	(162,591,780.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	180,054,335.40	175,002,235.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(116,200,941.96)	(132,713,824.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,593,617.87	95,593,617.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,857,307.50)	(56,448,298.53)
39209	Зам, гүүрийн байгууламж	263,906,626.00	263,906,626.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(154,568,290.68)	(166,929,978.97)
39214	Бусад үндсэн хөрөнгө	344,296,550.00	393,496,775.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(244,401,374.35)	(251,347,674.15)
39217	Ном	5,847,512.00	5,847,512.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>403,232,400.00</b>	<b>403,396,400.00</b>
39301	Програм хангамж	2,305,000.00	5,305,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,305,000.00)	(2,805,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	403,232,400.00	400,896,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,932,877,839.53</b>	<b>5,859,888,737.62</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,932,877,839.53</b>	<b>5,859,888,737.62</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,932,877,839.53</b>	<b>5,859,888,737.62</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	311,171,729.17	311,171,729.17
51101	Өмч: - төрийн	311,171,729.17	311,171,729.17
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>5,375,397,711.20</b>	<b>5,311,728,931.27</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	5,375,397,711.20	5,384,718,033.18
51220	Тайлант үеийн үр дүн	-	(72,989,101.91)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	246,308,399.16	236,988,077.18

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,932,877,839.53	5,859,888,737.62
---	---	------------------	------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,673,498,038.41	1,319,414,531.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,067,111,024.41	1,044,173,610.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,266,759.00	27,683,619.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,820,000.0	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,000,100.00	4,219,450.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,446,659.00	23,464,169.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	983,844,265.41	1,016,489,991.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	983,844,265.41	1,016,489,991.00
12	Татварын бус орлого	606,387,014.00	275,240,921.50
120	Нийтлэг татварын бус орлого	606,387,014.00	275,240,921.50
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	606,387,014.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	526,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	605,861,014.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		176,625,579.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		98,615,342.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,471,628,787.42	1,382,551,599.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,471,628,787.42	1,382,551,599.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,434,960,097.69	1,355,340,110.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	658,236,496.01	708,379,248.20
210101	Үндсэн цалин	622,834,346.01	416,747,179.65
210102	Нэмэгдэл	-	257,486,224.32
210104	Урамшуулал	533,228.00	514,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	34,868,922.00	33,631,344.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,110,777.21	80,935,432.33
210201	Тэтгэврийн даатгал	54,645,130.40	55,360,875.33
210202	Тэтгэмжийн даатгал	6,916,381.00	6,519,894.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,440,470.22	3,355,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,168,815.15	3,356,129.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,939,980.44	12,343,434.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,306,667.21	143,270,747.06
210301	Гэрэл, цахилгаан	10,623,766.25	19,702,441.34
210302	Түлш, халаалт	59,352,900.96	123,568,305.72

210303	Цэвэр, бохир ус	330,000.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>66,383,610.00</b>	<b>24,382,712.00</b>
210401	Бичиг хэрэг	3,009,900.00	2,238,200.00
210402	Тээвэр, шатахуун	41,858,778.00	14,905,982.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,044,700.00	1,715,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,470,232.00	5,523,130.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,500,000.00</b>	<b>500,000.00</b>
210502	Хоол, хүнс	820,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,680,000.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,500,000.00</b>	<b>8,538,839.00</b>
210604	Урсгал засвар	2,500,000.00	8,538,839.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,392,000.00</b>	<b>4,250,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,392,000.00	4,250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,681,679.40</b>	<b>2,857,681.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,725,650.00	1,420,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,650.00	158,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	337,065.40	163,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	262,400.00	0.00
210807	Газрын төлбөр	879,914.00	827,681.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>531,848,867.86</b>	<b>382,225,451.18</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	227,657,020.00	99,484,793.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	3,364,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	302,691,847.86	279,376,657.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,668,689.73</b>	<b>27,211,488.26</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,333,322.00</b>	<b>10,260,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	35,333,322.00	7,260,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>16,951,488.26</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	16,951,488.26
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,335,367.73</b>	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,335,367.73	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>201,869,250.99</b>	<b>(63,137,067.53)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,244,496.06</b>	<b>9,852,034.38</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,244,496.06	
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө		9,852,034.38
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>-3,244,496.06</b>	<b>-9,852,034.38</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>198,624,754.93</b>	<b>(72,989,101.91)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,067,637,024.41</b>	<b>1,044,173,610.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>526,000.00</b>	<b>-</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>526,000.00</b>	<b>-</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	526,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	526,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,067,111,024.41</b>	<b>1,044,173,610.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>83,266,759.00</b>	<b>27,683,619.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,820,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,000,100.00	4,219,450.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,446,659.00	23,464,169.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>983,844,265.41</b>	<b>1,016,489,991.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	983,844,265.41	1,016,489,991.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,061,787,125.41</b>	<b>1,025,433,710.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,061,787,125.41</b>	<b>1,025,433,710.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,024,118,435.68</b>	<b>998,222,221.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>651,252,546.73</b>	<b>706,942,560.35</b>
210101	Үндсэн цалин	615,850,396.73	415,310,491.80
210102	Нэмэгдэл	0.00	257,486,224.32
210104	Урамшуулал	533,228.00	514,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	34,868,922.00	33,631,344.23
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>91,480,414.34</b>	<b>80,935,432.33</b>
210201	Тэтгэврийн даатгал	66,144,523.04	55,360,875.33
210202	Тэтгэмжийн даатгал	6,349,566.00	6,519,894.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,144,034.00	3,355,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,140,927.30	3,356,129.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,701,364.00	12,343,434.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>71,026,667.21</b>	<b>141,920,747.06</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,623,766.25	19,702,441.34
210302	Түлш, халаалт	60,072,900.96	122,218,305.72
210303	Цэвэр, бохир ус	330,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,233,928.00</b>	<b>23,641,512.00</b>
210401	Бичиг хэрэг	2,582,900.00	2,052,200.00
210402	Тээвэр, шатахуун	25,759,678.00	14,905,982.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,044,700.00	1,715,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,846,650.00	4,967,930.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,750,000.00</b>	<b>500,000.00</b>

210502	Хоол, хүнс	820,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,930,000.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,010,000.00</b>	<b>8,538,839.00</b>
210604	Урсгал засвар	3,010,000.00	8,538,839.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,506,000.00</b>	<b>4,250,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,506,000.00	4,250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,681,679.40</b>	<b>2,857,681.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,725,650.00	1,420,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,650.00	158,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	337,065.40	163,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	262,400.00	-
210807	Газрын төлбөр	879,914.00	827,681.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>150,177,200.00</b>	<b>28,635,450.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	148,677,200.00	25,271,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	3,364,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>37,668,689.73</b>	<b>27,211,488.26</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>36,333,322.00</b>	<b>10,260,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	35,333,322.00	7,260,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	3,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,335,367.73</b>	<b>16,951,488.26</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,335,367.73	16,951,488.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>5,849,899.00</b>	<b>18,739,900.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>5,849,899.00</b>	<b>18,739,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,849,899.00</b>	<b>18,739,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>5,849,899.00</b>	<b>18,739,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,849,899.00	18,739,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(5,849,899.00)</b>	<b>(18,739,900.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(0.00)</b>	<b>-</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
С01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	197,728,780.04	5,328,159,177.44	5,525,887,957.48

C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		246,308,399.16	5,176,772,956.27	5,423,081,355.43
C07	Тайлант үеийн үр дүн			198,624,754.93	198,624,754.93
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,171,729.17	246,308,399.16	3,375,397,711.20	5,932,877,839.53
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	311,171,729.17	246,308,399.16	3,375,397,711.20	5,932,877,839.53
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			9,320,321.98	9,320,321.98
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-9,320,321.98		-9,320,321.98
D08	Тайлант үеийн үр дүн			-72,989,101.91	-72,989,101.91
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,171,729.17	236,988,077.18	5,311,728,931.27	3,859,888,737.62

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Д/Д	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,054,320,200.00</b>	<b>995,066,602.74</b>	<b>53,253,697.26</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,054,320,200.00	995,066,602.74	59,253,597.26
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,044,060,200.00</b>	<b>984,806,602.74</b>	<b>59,253,597.26</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	721,136,700.00	706,428,060.35	14,708,639.65
210101	Үндсэн цалин	687,427,000.00	415,310,491.80	272,116,508.20
210102	Нэмэгдэл	-	257,486,224.32	(257,486,224.32)
210105	Гэрээт ажлын хөлс	33,709,700.00	33,631,344.23	78,355.77
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>90,639,400.00</b>	<b>80,876,264.33</b>	<b>9,763,135.67</b>
210201	Тэтгэврийн даатгал	61,810,500.00	55,317,142.33	6,493,357.67
210202	Тэтгэмжийн даатгал	7,207,400.00	6,515,778.00	691,622.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,603,600.00	3,355,100.00	248,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,603,600.00	3,355,100.00	248,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,414,300.00	12,333,144.00	2,081,156.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>145,090,400.00</b>	<b>141,114,747.06</b>	<b>3,975,652.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	21,640,500.00	18,896,441.34	2,744,058.66
210302	Түлш, халаалт	122,521,800.00	122,218,305.72	303,494.28
210303	Цэвэр, бохир ус	928,100.00	-	928,100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,655,700.00</b>	<b>19,023,400.00</b>	<b>4,632,300.00</b>
210401	Бичиг хэрэг	2,728,000.00	2,052,200.00	675,800.00

210402	Тээвэр, шатахуун	11,760,300.00	11,760,200.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,408,400.00	1,715,400.00	693,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	225,000.00	-	225,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,534,000.00	3,495,600.00	3,038,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>499,400.00</b>	<b>500,000.00</b>	<b>(600.00)</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	499,400.00	500,000.00	(600.00)
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,391,900.00</b>	<b>5,391,000.00</b>	<b>3,000,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	-	3,000,000.00
210604	Урсгал засвар	5,391,900.00	5,391,000.00	900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,330,800.00</b>	<b>4,250,000.00</b>	<b>80,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,330,800.00	4,250,000.00	80,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,665,600.00</b>	<b>1,437,681.00</b>	<b>4,227,919.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	183,700.00	158,400.00	25,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,600.00	163,600.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	-	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,442,300.00	-	3,442,300.00
210807	Газрын төлбөр	1,500,000.00	827,681.00	672,319.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,650,300.00</b>	<b>25,785,450.00</b>	<b>18,864,850.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,135,800.00	25,271,450.00	18,864,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	514,500.00	514,000.00	500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,260,000.00</b>	<b>10,260,000.00</b>	<b>-</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,260,000.00</b>	<b>10,260,000.00</b>	<b>-</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,260,000.00	7,260,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	3,000,000.00	-
<b>22</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>0.00</b>	<b>5,999,900.00</b>	<b>-5,999,900.00</b>
	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>5,999,900.00</b>	<b>-5,999,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	5,999,900.00	-5,999,900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,054,320,200.00</b>	<b>1,001,066,502.74</b>	<b>53,253,697.26</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,054,320,200.00</b>	<b>1,001,066,502.74</b>	<b>53,253,697.26</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,054,320,200.00	1,001,066,502.74	53,253,697.26

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>13,415,619.00</b>	<b>(13,415,619.00)</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>13,415,619.00</b>	<b>(13,415,619.00)</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>13,415,619.00</b>	<b>(13,415,619.00)</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	<b>514,500.00</b>	<b>(514,500.00)</b>
210104	Урамшуулал	-	514,500.00	(514,500.00)
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	<b>59,168.00</b>	<b>(59,168.00)</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	43,733.00	(43,733.00)
210202	Тэтгэмжийн даатгал	-	4,116.00	(4,116.00)
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,029.00	(1,029.00)
210205	Эрүүл мэндийн даатгал	-	10,290.00	(10,290.00)
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>806,000.00</b>	<b>(806,000.00)</b>
210301	Гэрэл, цахилгаан	-	806,000.00	(806,000.00)
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>4,618,112.00</b>	<b>(4,618,112.00)</b>
210402	Тээвэр, шатахуун	-	3,145,782.00	(3,145,782.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,472,330.00	(1,472,330.00)
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>3,147,839.00</b>	<b>(3,147,839.00)</b>
210604	Урсгал засвар	-	3,147,839.00	(3,147,839.00)
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>1,420,000.00</b>	<b>(1,420,000.00)</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,420,000.00	(1,420,000.00)
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>2,850,000.00</b>	<b>(2,850,000.00)</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,850,000.00	(2,850,000.00)
22	<b>Хөрөнгийн зардал</b>	-	<b>12,740,000.00</b>	<b>-12,740,000.00</b>
	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>12,740,000.00</b>	<b>-12,740,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	12,740,000.00	-12,740,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>26,155,619.00</b>	<b>(26,155,619.00)</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>26,155,619.00</b>	<b>(26,155,619.00)</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,219,450.00	(4,219,450.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	21,936,169.00	(21,936,169.00)

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Хяргас сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн

тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хяргас сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн "ctsystem" программ ашиглан бэлтгэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 72,989.1 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	2,385.7	949.0	-1,436.7
Урьдчилгаа			
Бараа материал	211,449.2	233,760.0	22,310.8
Үндсэн хөрөнгө	5,719,042.9	5,625,179.7	-93,863.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,932,877.8</b>	<b>5,859,888.7</b>	<b>-72,989.1</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,932,877.8	5,859,888.7	-72,989.1
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,932,877.8	5,859,888.7	-72,989.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>5,932,877.8</b>	<b>5,859,888.7</b>	<b>-72,989.1</b>

Мөнгөн хөрөнгийн дансны эхний болон эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 949.0 мянган төгрөг болж 1,436.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 233,760.0 мянган төгрөг болж 22,310.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд бараа материал данс 142,569.7 мянган төгрөгөөр нэмэгдэж 120,258.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 5,625,179.7 мянган төгрөг болж 93,863.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 195,365.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 81,473.8 мянган төгрөгийн хөрөнгө акталж, тайлант онд 279,376.6 төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсоноос голлон шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны эхний болон эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,859,888.7 мянган төгрөг болж 72,989.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс голлон шалтгаалсан байна.

2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 354,083.5 мянган төгрөгөөр буюу 21.1 хувиар буурсан байна. Орлого буурахад нэмэлт санхүүжилтын орлого болон татварын бус орлого данс буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 89,077.2 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар буурсан байна. Зарлага буурахад хангамж, бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардал буурсан нь голлон нөлөөлжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвөөс 1,447,624.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 360,168.0 мянган төгрөгөөр буурч 1,087,456.0 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь 2025 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловруулахаас гадна хангамж бараа материал, болон эд хогшил худалдан авах зардал, бусдаар гүйцэтгэсэн төлбөр хураамж гэсэн зардлуудыг бүрэн гүйцэт төлөвлөгдөж ирээгүйгээс шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 11 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 1,054,320.2 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 995,066.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 995,066.6 мянган төгрөг буюу 94.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 27,153.4 мянга, баг хорооны үйл ажиллагааны зардлыг 3,134.0 мянга, тогтмол зардлыг 3,784.7 мянга, нийтлэг үйлчилгээний зардлыг 92.3 мянга, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлыг 8,684.7 мянга, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлыг 9,579.6 мянга, мал тооллогын зардлыг 600.0 мянга, хог хаягдал зайлуулах зардлыг 225.0 төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	596,709.5	569,556.1	27,153.4	95.4%
2	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Баг хорооны ҮА-ны зардал-80106	176,658.3	173,524.3	3,134	98.2%
3	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Төрийн өмчийн барилгын тогтмол зардал-80111	147,749.4	143,964.7	3,784.7	97.4%
4	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Нийтлэг үйлчилгээ-80112	78,582.2	78,489.9	92.3	99.9%
5	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Ажил олгогчоос олгох тэтгэмж-80802	10,260.0	10,260.0	0	100.0%
6	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Орон нутгийн нөөц хөрөнгө-81102	23,100.0	14,415.3	8,684.7	62.4%
7	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Мал тооллого- 81507	600,0		600.0	0%
8	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Хур хог хаягдал орчны бохирдол- 82212	225.0		225.0	0%

9	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Улсын баяр наадам- 82801	5,000.0	5,000.0	0	100%
10	Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх-71413 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх-81701	14,835.8	5,256.2	9,579.6	35.4%
11	Ахмад насны хөгжлийн хамгаалал-72208 Ахмадын сан-81549	600.0	600.0	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	3,000.0	3,000.0	Си ти эс программ ашигладаг.
2	Унаа, хоолны зардал	0.0	0.0	Унаа хоолны зардал олгоогүй байна.
3	Сургалт, семинар	2,000.0	2,000.0	Улаанбаатар хотод удирдлагын академийн сургалтад хувиарын дагуу явахаар 2,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	0.0	Гадаад томилолтын зардал байхгүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	0.0	0.0	Орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл, мэдээлэл	0.0	0.0	Хэвлэл, мэдээллийн зардал байхгүй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4,219.4 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 21,936.2 мянга, нийт 26,155.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс: Урамшуулалд 514.5 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 59.2 мянга, гэрэл цахилгаан 806.0 мянга, тээвэр шатахууны зардалд 3,145.8 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 1,472.3 мянга, багаж техник хэрэгсэлийн зардалд 2,740.0 мянга, тавилга 10,000.0 мянга, урсгал засварын зардалд 3,147.8 мянга, мэргэжлийн үйлчилгээний төлбөрийн зардалд 1,420.0 мянга, сургалт, дадлага бэлтгэлийн зардалд 2,850.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн дансны хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70106: Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	26,155.6	26,155.6	0	100.0%

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Хяргас сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, харин байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах 18,739.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамж, мөн 43,954.4 мянган төгрөгийн бараа материалыг тайлант онд шууд худалдан авалт хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02/12 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,471,628.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 14,716.3 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 11,773.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,382,551.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 13,825.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 11,060.4 мянган төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Хяргас сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хяргас сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 61,883.4 мянган төгрөгийн 6 зарлагын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 419,867.3 мянган төгрөгийн 6 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 53,580.6 мянган төгрөгийн 41 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 651,693.7 мянган төгрөгийн 8 орлогын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27,401.7 мянган төгрөгийн 4 зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 14,062.2 мянган төгрөгийн 5 шийдвэрийн мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлангийн 351,262.3 мянган төгрөгийн 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Увс аймгийн Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,417.5 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 667.5 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 1,750.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн байна. Төлбөрийн актын биелэлтийг Хяргас сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 02/68 дугаар албан бичгээр, Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 2/85 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан Хяргас сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоонд байхгүй селесерь, олон нийтийн байцаагч, манаач, сахиулыг авч ажиллуулж төсвөөс 73,260.7 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ асуудлыг судалж шийдвэрлэсэн эсэхийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,587,695.7 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс 7,944.5 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,579,751.2 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өглөө.

### Залруулсан алдаа:

1. Тамгын газрын бараа материалын тайлангийн мал амьтад дансанд бүртгэлтэй Герефорд үйлдвэрийн 7,944.5 мянган төгрөгийн 2 бухыг нас дэвшилт хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 5.1.5 дэх заалтад “Хэмжигдэхүйц байх”, 14.4.7 дахь заалтад Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул нас дэвшилт хийж залруулга хийлгэлээ.

### 5.2 Албан шаардлага:

Хяргас сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 61,883.4 мянган төгрөгийн 6 зарлагын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 419,867.3 мянган төгрөгийн 6 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 53,580.6 мянган төгрөгийн 41 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 651,693.7 мянган төгрөгийн 8 орлогын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27,401.7 мянган төгрөгийн 4 зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 14,062.2 мянган төгрөгийн 5 шийдвэрийн мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлангийн 351,262.3 мянган төгрөгийн 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 дахь заалтад “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нас дэвшилт хийгээгүй	1	7,944.5			1	7,944.5	1	7,944.5				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>7,944.5</b>			<b>1</b>	<b>7,944.5</b>	<b>1</b>	<b>7,944.5</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст 53 мэдээлэл байршуулаагүй, 18 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	1,579,751.2			1	1,579,751.2		
Дүн	1	1,579,751.2			1	1,579,751.2		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



М.БАТСУУРЬ/

М.БАТ-АМГАЛАН/

Т.БАТСҮХ/

2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр